

УЛААНБААТАР ХОТ


“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”-  
ОНӨТҮГ-ын даргын 2019 оны 10 дарсарын 26  
өдрийн 10/26 тоот тушаалын хавсралт

6046231 + 1116117863



**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОРОН  
НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДУНД  
ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**(2019-2022 он)**



**Улаанбаатар хот  
2019 он**

## АГУУЛГА

НЭГ. ӨМНӨХ ҮГ

ХОЁР. ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН МЭДЭГДЭЛ

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

3.1 “Бэлчээрийн менежмент төслийн нэгж”- ОНӨТҮГ-ын алсын хараа

3.2 “Бэлчээрийн менежмент төслийн нэгж”- ОНӨТҮГ-ын алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зарчим

3.3 “Бэлчээрийн менежмент төслийн нэгж”- ОНӨТҮГ-ын орчны шинжилгээ

3.4 Үйл ажиллагааны стратегийн зорилт

3.5 Үйл ажиллагааны хамрах хүрээ

3.6 Стратегийн зорилт, эн тэргүүнд нийлүүлэх бүтээгдэхүүний анги хоорондын уялдаа

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

4.2 Хяналтын механизм

4.3 Хяналт шинжилгээ, үнэлгээ

4.3.1 Хяналт шинжилгээ, үнэлгээний зарчим

4.3.2 Хяналт шинжилгээ, үнэлгээний арга зүй

4.3.3 Хяналт шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүд

ТАВ. ӨМЧЛӨЛИЙН БУСАД ЗОРИЛТУУД

5.1. Өмчлөлийн зорилт

5.2. Санхүүгийн үйл ажиллагааны зорилт ба үзүүлэлтүүд

5.3. Нөөцийн ашиглалт сайжруулалт

✓ Хүний нөөц

ЗУРГАА. ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

6.1. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдээлэл

6.2. Нягтан бодох бүртгэлийн бодлого ба төсвийн таамаглалын талаархи мэдээлэл

6.3. Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд

## НЭГ. ӨМНӨХ ҮГ

“Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хуулийн дагуу Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 93 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн /бизнес/ төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, “төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн /бизнес/ төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”-ын дагуу “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын 2019-2022 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулав.

Ойрын 5-н жилд “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-аас баримтлах эрхэм зорилго, стратегийн бодлого, зорилт, үйл ажиллагааны цөм нь өндөр хөгжилтэй орнуудын бэлчээрийн менежментийг сайжруулах талаар хөгжүүлсэн арга туршлагаас өөрийн үйл ажиллагаанд үр ашигтай хэрэгжүүлэх, бэлчээрийн талхагдлыг бууруулах, шинэ төрлийн ногоон тэжээл үйлдвэрлэлийг нэвтрүүлэхэд оршино.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын хэтийн төлөвлөгөөнд дараах зүйлүүдийг багтаасан болно. Үүнд:

- “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зарчим, стратегийн зорилт буюу ойрын 5-н жилд худалдан авах, нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ
- “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-аас Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид жил бүр нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, тэдгээрийн өртөг /хавсралтаар/
- “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын бүтэц зохион байгуулалт, ажил үүргийн хуваарь
- Ерөнхий менежерийн зүгээс байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, хүний нөөцийн чадварыг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлэх болон өмчлөлийн эрхтэй холбогдсон бусад асуудлууд зэрэг болно.

Стратеги төлөвлөгөө нь байгууллагын эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нөөц бололцоо, хүчин чармайлт, цаг хугацааг хэрхэн төвлөрүүлэх арга замыг тодорхойлж хамтдаа хөгжих бодлогын баримт бичиг юм.

## ХОЁР. ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН МЭДЭГДЭЛ

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ- нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр захирамж зэргийг мөрдлөг болгон, тэдгээртэй нийцүүлэн төлөвлөгөө боловсруулж гаргах, биелэлтэнд хяналт тавих, мэргэжил арга зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлж, төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх зарчмыг баримтлан ажиллана.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын 2019-2022 оны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь:

- “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зарчим, стратегийн зорилт буюу ойрын таван жилд худалдан авах, нийлүүлэх, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ
- “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-аас бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид жил бүр нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, тэдгээрийн өртөг /хавсралтаар/
- “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын бүтэц зохион байгуулалт, ажил үүргийн хуваарь
- Ерөнхий менежерийн зүгээс байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлэх болон өмчлөлийн эрхтэй холбогдсон бусад асуудлууд зэрэг болно.

Энэхүү үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний хүрээнд томьёолсон стратегийн зорилт, түүний хүрэх үр дүн, нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тэдгээрийн тодорхойлолтыг дунд хугацаанд тогтвортой мөрдөж ажиллах болно. Тухайн жилд нийлүүлэх бүтээгдэхүүнийг хүрэх үр дүн болон хэтийн зорилттой уялдуулан боловсруулж, түүнд шаардагдах төсвийн

санхүүжилтийг Төсвийн өрөнхийлөн захирагчаар батлуулан, гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, нийлүүлэх бүтээгдэхүүн болон хэрэгжүүлэх арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг ханган биелүүлэхэд чиглэгдэнэ.

Нийслэл орчмын бэлчээрийн талхагдлыг бууруулах талаар олон улсын тэргүүний технологи, ажлын туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, шинэ төрлийн ногоон тэжээл үйлдвэрлэх ажлыг эрчимжүүлж, саалийн хугацаанд авах сүүний гарцыг нэмэгдүүлснээр нийслэлийн хүн амын сүүний хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангах, хөдөө аж ахуйн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулах зэрэг ажилд бодитой хувь нэмэр оруулна.

Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр нийслэлийн хэмжээнд эрчимжсэн мал аж ахуйн загвар ферм, сургалтын төв болон хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж бүхий Техник дундын үйлчилгээний төв бий болж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд орчин үеийн дэвшилтэт шинэ техник, технологи танилцуулах, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгын дагуу хөдөө аж ахуйн үйлчилгээг хямд үнээр чанарын өндөр түвшинд гүйцэтгэх боломж бүрдэх болно.



## ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

### 3.1 “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын алсын харaa /vision/

Нийслэлийн хэмжээнд бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр нэвтрүүлж буй орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нутагшуулах болон иргэд, аж ахуйн нэгжид техникийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий жишиг төв болно.

### 3.2 “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-ын эрхэм зорилго /mission/

Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, шинэ төрлийн ногоон тэжээлийн үйлдвэрлэлийг нэвтрүүлсний үр дүнд саалийн хугацаанд авах сүүний гарцыг нэмэгдүүлж, нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах ажилд бодит хувь нэмэр оруулна.

### Эрхэмлэх зарчим буюу үнэт зүйлс /values/

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, бэлчээрийн менежменийг сайжруулах замаар мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, ногоон тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, сүүний гарцыг нэмэгдүүлэх, иргэд аж ахуйн нэгжид газар тариалангийн үйлчилгээг чанарын өндөр түвшинд хямд үнээр үзүүлэх зэрэг ажлуудыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГ-нь дараах үндсэн зарчмыг үйл ажиллагаандaa эрхэмлэнэ.

#### Эрхэмлэх зарчим 1. Хуулийг баримтлах

Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжийн хүрээнд явагдана.

#### Эрхэмлэх зарчим 2. Мэргэшсэн тогтвортой, шинийг санаачлагч

Төрийн албаны тухай хуулиар бид мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бүрдүүлж, албан хаагчдынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэх, санал санаачлагыг дэмжиж ажиллана.

#### Эрхэмлэх зарчим 3. Хэрэглэгчээ дээдлэх

Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх газрын үйл ажиллагаа нь хэрэглэгчээ дээдэлсэн, олон нийтэд чиглэсэн байна.

#### Эрхэмлэх зарчим 4. Ил тод, нээлттэй байх

Газрын үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй байх бөгөөд иргэдийн санал бодол, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн идэвхи оролцоонд тулгуурлана.

#### Эрхэмлэх зарчим 5. Шударга ардчилсан ёс

Иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэхдээ нас хүйс, яс үндэс, мэргэжил боловсролоор ялгаварлалгүйгээр шударга ёсыг баримтлана.

### 3.3 “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” – ОНӨТҮГЫН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

#### Хүснэгт 1. SWOT шинжилгээний бүрэлдэхүүн хэсгүүд

Бүрэлдэхүүн хэсгүүд	Давуу тал /Strengths/	Сул тал /Weaknesses
ДОТООД ОРЧИН	<ul style="list-style-type: none"> <li>Хүлээсэн чиг үүрэг, батлагдсан бодлого, хөтөлбөртэй.</li> <li>Эрхлэх асуудлын хүрээнд бие даасан бүтэц, зохион байгуулалттай.</li> <li>Ажиллах орчин нөхцөл, компьютер, тоног төхөөрөмжийн хангарт сайн бүрдсэн.</li> <li>Мэргэжлийн боловсон хүчний хангарт сайн</li> <li>Гадаад, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагаатай.</li> <li>Дотоод албан хэрэг хөтлөлтийн программ нэвтэрсэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сул</li> <li>Гадаад харилцаа, хамтын ажиллагаа хангалтгүй</li> <li>Албан хаагчдын нийгмийн баталгаа хангалтгүй</li> </ul>
ГАДААД ОРЧИН	<p><b>Боломж /Opportunities/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад хамтын ажиллагаа сайжруулах замаар дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандaa нэвтрүүлэх,</li> <li>Эрдэм шинжилгээний бусад байгууллагуудтай хамтран ажилладаг.</li> <li>Шинэ санаа, бүтээлч үйл ажиллагааг идэвхжүүлэх боломж нөхцлөөр хангадсан.</li> <li>Ажлын байр нэмэгдэж, иргэд, Аж ахуй нэгж, малчид фермерүүдийг сургалтанд хамруулах боломж бүрдэнэ.</li> </ul>	<p><b>Бэрхшээл /Threats/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Нийслэлийн тэсвийн хөрөнгө оруулалт дутмаг</li> <li>Санхүү, эдийн засгийн хүндрэлээс шалтгаалж, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй</li> <li>Малчдын хоршоо байгуулах болон бэлчээрийн талхагдлыг хэрхэн бууруулах талаар малчид, фермерүүдийн мэдлэг муу.</li> <li>Иргэн, аж ахуйн нэгжид бэлчээрийг зохистой ашиглах талаар шалгалт хийх, хариуцлага тооцох эрхзүйн орчин бүрдээгүй.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>Уургат ногоон тэжээлийн хангамж нэмэгдэнэ.</li> <li>Фермерүүд тэжээлийн зардлыг бууруулж, эдийн засгийн хувьд ашигтай ажиллах боломжтой.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Туршилтын талбайд технологийн дагуу усалгаа хийх боломж муу, байнгын услалтын систем байхгүй, тул байгалаын хур тундасаас хэт их хамааралтай</li> </ul>
--	--	--

### SWOT шинжилгээний дүгнэлт:

Манай байгууллага нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар нийслэлийн хүн амын сүүний хангамжийг сайжруулах, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчидэд чанар сайтай техникийн үйлчилгээ үзүүлэх зорилго тавин ажилладаг. Тус байгууллагын албан хаагчдаас түүвэрлэн авсан саналд гадаад, дотоод орчинд SWOT шинжилгээ хийж үзэхэд төсөл хэрэгжүүлэх гадаадын болон дотоодын мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмжийн хангамж сайн, ойр хавийн малчид, фермерүүдэд сургалт явуулж, зөвлөгөө өгөхөд боломж бүрдсэн зэрэг нь давуу тал болж байна. Мөн Бүгд Найрамдах Австри улсын хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн НОУХАУ-г монголын хөрсөнд нутагшуулах ажил амжилттай хэрэгжиж, хамтын ажиллагаа түлхүү хөгжсөн давуу тал байна.

Гадаад орчны тулгарч буй сул талууд :

Байгууллагын хэмжээнд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсөв хөрөнгө дутмаг, нийслэлийн бусад байгууллагатай хамтран ажиллах уялдаа холбоо муу. Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр хяналт, шалгалт хийх эрх зүйн орчин бүрдээгүй нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээнд нөлөөлж байна.

Дээрхи шинжилгээний үр дүнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах 'Санамж бичиг болон хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах
- БНАУ-аас гадна хөдөө аж ахуй, бэлчээрийн менежментийн чиглэлээр өндөр хөгжилтэй бусад орнуудтай хамтран ажиллах, туршлага солилцох, үйл ажиллагаандaa нэвтрүүлэх
- Нийслэлийн төсөвт төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг суулгах
- Иргэд, олон нийтэд өөрийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилах чиглэлээр хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах
- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх замаар албан хаагчдын амьдралд дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүд болно.

### 3.4 Үйл ажиллагааны стратегийн зорилт

- Эрс тэс уур амьсгалтай, уулархаг бус нутагт дасан зохицсон, хөрс болон тэжээлийн чанарыг сайжруулах чадвар бүхий Австри улсад үйлдвэрлэсэн "NATRO" олон наст үрийн

холимгийг монголын нөхцөлд нутагшуулсны үр дүнд бэлчээрийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулан, ногоон тэжээлийн шинэ төрлийг бий болгох

- Техник дундын үйлчилгээний төвийг байгуулсны үр дүнд чанарын шаардлага хангасан газар тариалангийн үйлчилгээг хямд үнээр иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх
- Сургалтын төв, туршилтын талбай, үнээний ферм болон засварын төв бүхий Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй байгуулах

### 3.5 Үйл ажиллагааны хамрах хүрээ

“Бэлчээрийн менежмент” төслийн нэгж ОНӨТҮГ-нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгыг нийслэлийн хэмжээнд амжилттай хэрэгжүүлэх зорилго бүхий орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар болно.

3.6 Стратегийн зорилт, эн тэргүүнд нийлүүлэх бүтээгдэхүүний анги хоорондын уялдаа “Бэлчээрийн менежмент” төслийн нэгж ОНӨТҮГ нь дээр дурьдсан үйл ажиллагааны стратегийн зорилтуудыг хангахын тулд 2019-2022 онд холбогдох байгууллагад дараахь бүтээгдэхүүнийг нийлүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

Эрхэм зорилго	Стратегийн зорилт буюу бүтээгдэхүүний ерөнхий анги	Д/Д	Тактикийн зорилт буюу эн тэргүүнд нийлүүлэх бүтээгдэхүүний анги
Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, шинэ төрлийн ногоон тэжээлийн үйлдвэрлэлийг нэвтрүүлсний үр дүнд саалийн хугацаанд авах сүүний гарцыг	1.Эрс тэс уур амьсгалтай, уулархаг бүс нутагт дасан зохицсон, хөрс болон тэжээлийн чанарыг сайжруулах чадвар бүхий Австри улсад үйлдвэрлэсэн “NATRO” олон наст үрийн холимгийг монголын нөхцөлд нутагшуулсны үр дүнд бэлчээрийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулан, ногоон тэжээлийн шинэ төрлийг бий болгох	1.1	“NATRO” олон наст үрийн холимогоор Гуттлер үрлэгчийг ашиглан тариалалтын ажлыг явуулах
		1.2	Малын өтөг бууц, шивх зэрэг органик бордоо ашиглан, туршилтын талбайг бордож, хөрсний чанарыг сайжруулах
		1.3	Хөрсний шинжилгээний үр дүнгээс хамааран шаардлагатай нөхцөлд Азот, фосфор, кали /NPK-/ийн нийлмэл бордоогоор туршилтын талбайг бордох,
		1.4	Туршилтын талбайгаас өвс хадлан хураан авч, пресслэх, вакумжуулан боож, шинэ төрлийн ногоон тэжээл бэлтгэх

нэмэгдүүлж, нийслэлийн хүн амыг сүүн бүтээгдэхүүнээр хангах ажилд бодит хувь нэмэр оруулах.		1.5	NATRO олон наст үрийн холимогийг монголын нөхцөлд нутагшуулж, энэ терлийн үрийг гарган авах, цаашид үйлдвэрлэн, хэрэглэгчдэд нийлүүлэх
	2. Техник дундын үйлчилгээний төвийг байгуулсны үр дүнд иргэн, аж ахуйн нэгжид чанарын шаардлага хангасан газар тариалангийн үйлчилгээг үзүүлэх	2.1	Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглан иргэн, аж ахуйн нэгжийн захиалгын дагуу чанарын өндөр түвшинд хямд үнээр газар тариалангийн үйлчилгээг үзүүлэх
	2.2	Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг цаг тухайд нь гүйцэтгэж, байнгын бэлэн байдлыг хангаж ажиллах	
	2.3	Иргэн аж ахуйн нэгжийн захиалгын дагуу техник, тоног төхөөрөмжийн засварын ажлыг гүйцэтгэх, шаардлагатай сэлбэг хэрэгслийг цаг алдалгүй нийлүүлэх	
	3. Сургалтын төв, туршилтын талбай болон засварын төв бүхий Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахийг байгуулах	3.1	Эрчимжсэн мал аж ахуйн фермийн байнгын үйл ажиллагааг хангаж ажиллах
		3.2	Малын эрүүл мэндийн үзлэг болон урьдчилан сэргийлэх тарилга, вакцинжуулалтанд байнга хамруулах, зриомол хээлтүүлгийн ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх
		3.3	Нийслэлийн иргэд, малчид фермерүүдэд зориулж, хөдөө аж ахуйн чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулах

## ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 4.1. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”, Нийслэлийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.1-д заасан Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтыг хэрэгжүүлэх, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар юм.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”-ОНӨТҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдана. Даргыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

**Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн A/493 тоот захирамжаар Бэлчээрийн менежмент төслийн нэгж – ОНӨТҮГ-ын анхны бүтэц орон тоог баталсан. Үүнд:**

1. Газрын дарга
2. Төслийн менежер, орчуулагч
3. Агрономч
4. Мэргэжилтэн туслах
5. Сургагч багш оператор
6. Нярав, талбайн зохион байгуулагч
7. Тоног төхөөрөмжийн оператор
8. Манаач, туслах малчин

**Харин Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн A/282 тоот захирамжаар Бэлчээрийн менежмент төслийн нэгж – ОНӨТҮГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, дараахь бүтцийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:**

№	Албан тушаалын нэрс	Ажил үүргийн хуваарь	Албан тушаалын тоо
1	Дарга	Төсвийн шууд захирагч, байгууллагын байнгын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлнэ.	1
2	Төслийн менежер	Австри улсын мэргэжилтнүүд болон бусад гадаад, дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, тусгай хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагаанд даргын өгсөн чиг үүргийн дагуу хяналт тавьж, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулна.	1
3	Нягтлан бодогч	Төслийн нэгжийн бэлэн мөнгөний гүйлгээ, санхүүгийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хянаж, төсвийн гүйцэтгэлийг тайлагнаж, жил тутмын төслийг боловсруулна.	1
4	Агрономч	Төсөл хэрэгжүүлэх талбайн хөрсний үржил шимийг тогтоох, Австрийн мэргэжилтнүүдийн гаргасан тусгай хуваарийн дагуу хаврын тариалалт, бордолт болон хадлан тэжээл хураан авах ажлыг хариуцан ажиллана.	1
5	Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, даргын туслах, архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын дотоод хяналтын ажлыг хэрэгжүүлнэ.	1

6	Механик инженер	Төслийн хүрээнд нийлүүлэгдсэн бүх техник, тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, угсралт тохиргоо, засвар үйлчилгээг хариуцан ажиллана.	1
7	Нярав	Байгууллагын нийт эд хөрөнгө, сургалтын төвийн болон фермийн байгууламж, техник тоног төхөөрөмжүүдийг бүртгэх, данслах, тооллого явуулах зэрэг ажлыг хариуцаж ажиллана.	1
8	Тоног төхөөрөмжийн оператор	Сургалт үйлдвэрлэлийн талбайд тэжээлийн ургамлын тариалалт, бордолт болон хадлан авах зорилгоор машин техник, тоног төхөөрөмжүүдийг ажиллуулна.	1
9	Фермер	Малын арчилгаа, маллагааг хариуцах, саалийн үнээний сүүний гарцыг тогтмол хөтлөх, фермийн өдөр тутмын ажлыг хариуцан ажиллана.	
10	Манаач	Төслийн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд туслах ба аж ахуйн нэгжийн байр, агуулах, хашаа бусад объектыг манаах, гадны халдлагаас хамгаалах.	1
Нийт			10

#### 4.2. Хяналтын механизм:

Энэхүү хяналтын механизм нь Ерөнхий менежер өөрийн эрх үүргийн хүрээнд байгууллагын эд хөрөнгийг хамгаалах, хүний нөөцийн чадварыг бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон өмчлөлийн эрхтэй холбогдсон бусад асуудлуудыг Төсвийн тухай хууль, Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийн дагуу төсөв зохиох, батлах, зарцуулах, тайлагнах, мөн төсвийн талаарх төрийн байгууллага, албан тушаалтны эрх үүрэг, үйл ажиллагааны зарчим, төсвийн хяналт, хариуцлага зэрэгтэй холбоо бүхий харилцааг зохицуулахад оршино.

Төсвийн байгууллага, албан тушаалтан нь удирдлага, санхүүжилт, хяналтын талаар дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Жилийн эхэнд үйл ажиллагааны зорилтыг тогтоож, хүрэх үр дүнг тодорхойлох
- Санхүүгийн жилд бүтээгдэхүүнээ гэрээний үндсэн дээр нийлүүлж, төсвийн санхүүжилт авах
- Албан хаагчийг зөвхөн мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадварын үндсэн дээр нээлттэй өрсөлдөөний зарчмаар томилох, ажлын үр дүнг нь бодитойгоор үнэлэх
- Санхүү төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх
- Мэдээ тайлангийн үнэн бодит байдлыг хангаж, харьцуулсан тоон мэдээлэлд үндэслэн хүрсэн үр дүнг хүрэх түвшинтэй уялдуулан товч бөгөөд тодорхой шаардлагатай мэдээлэл бүхий байдлаар боловсруулан дээд шатны байгууллага, албан тушаалтанд тайлагнаж хэвших

1. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу төсвийн удирдлага, санхүүжилтийн зарчмыг сахиулах, төсвийн удирдлага, санхүүжилтийг боловсронгуй болгох санал боловсруулан, эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх. Санхүү, төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах. Орон нутгийн өмч, улсын төсвийн хөрөнгийн эрсдлийг үр ашигтай удирдах зэрэг тодорхой чиг үүргийг эрхлэн гүйцэтгэнэ.
2. Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж захиргааны дотоод ажил, хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан албан хаагчдыг үйл ажиллагааны чиг үүргийг бүрэн зааглаж, Албан тушаалын тодорхойлолтод тусгаж баталгаажуулах. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан журмын дагуу дотоод мэдээ мэдээллийг дээд шатны байгууллагад хугцаанд нь хургуулж ажиллах.

#### **Хяналт шинжилгээ, үнэлгээний зарчим:**

1. Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хугацаанд үе шаттайгаар үнэлгээ өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг, даргын тушаалаар байгуулан ажиллана.
2. Байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг жил бүрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө болон үр дүнгийн гэрээнд тусгуулах, явцын хяналтыг тогтмол хийх үүргийг төслийн менежер хариуцан ажиллана.
3. Байгууллагын стратеги төлөвлөгөөнд явцын хяналт хийж, хагас бүтэн жилээр биелэлтийг дүгнэх ажил нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, удирдлагын үйл явцын үр нөлөөг үнэлж, сайжруулахад тус дэм болно.
4. Урьдчилсан болон нэгтгэн дүгнэх үнэлгээ нь хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүн, үр нөлөөг тогтооход чиглэнэ.
5. Стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох асуудлыг байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан хяналт, шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

#### **Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:**

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно.
2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг байгууллагын дарга батална.
3. Тайланд хяналт шинжилгээ хийхдээ хагас, бүтэн жилээр гаргасан тайлан, мэдээтэй танилцаж баримт бичгийг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.
4. Бодлогын зорилтын хэрэгжилтийн түвшинг тодорхойлоходоо тавьсан зорилтын

гүйцэтгэл тогтоох шалгуур үзүүлэлтийн үр дүнг /гүйцэтгэл/ хүрэх түвшин буюу тавьсан зорилтод /зорилт/ харьцуулж хувиар илэрхийлнэ.

5. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийг баримтална.

#### **4.3. Хяналт шинжилгээ үнэлгээний үзүүлэлтүүд**

4.3.1. Байгууллагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор улс, нийслэлийн төсвийг батлах, төсвийн тодотгол хийхээс өмнө үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай өртөгийг нь тооцож үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

4.3.2. Бодлогын зорилтын суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн, үр нөлөөг тоон үзүүлэлтээр тогтооно. Тоон үзүүлэлт тогтоох боломжгүй бол чанарын шалгуур үзүүлэлтийг аль болох тодорхой тогтооно.

4.3.3. Тухайн үйл ажиллагаа болон бодлого хэрэгжиж эхлэх жилийн улсын статистик мэдээллээр гаргасан үзүүлэлт, төрийн байгууллагаас албан ёсоор гаргаж, нийтэд мэдээлсэн тоон мэдээ зэргийг суурь үзүүлэлт болгон авна.

4.3.4. Шалгуур үзүүлэлт нь дараах шаардлагыг хангасан байна.

4.3.4.1. Хамааралтай буюу ач холбогдолтой байх.

4.3.4.2. Урт хугацаанд хэрэглэгдэх, тогтмол байх.

4.3.4.3. Хэрэглэхэд хялбар, боломжтой байх.

4.3.4.4. Аль болох богино хугацаанд өөрчлөлтийг илэрхийлэхээр байх.

#### **4.4. Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх**

4.4.1. Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэнд хийсэн хяналт шинжилгээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх.

4.4.1.1. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах.

4.4.1.2. Байгууллагын стратеги зорилтоос хариуцсан чиглэлийн хүрээнд албан хаагчид өөрийн тусгаж хэрэгжүүлэх.

4.4.1.3. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн шаардлагатай тохиолдолд стратегийг хэрэгжүүлэх арга хэлбэр, зохион байгуулах үйл ажиллагааг өөрчлөх асуудлыг байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тодотгох.


## ТАВ. ӨМЧЛӨЛИЙН БУСАД ЗОРИЛТУУД

### 5.1 Нөөцийн ашиглалт сайжруулалт


**Ажиллах хүчний нөөц:** Тус байгууллага нь Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/282 тоот захирамжаар батлагдсан шинэ бүтцээр Дарга, Төслийн менежер, Нягтлан бодогч, Агрономч, Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн, Механик инженер, Нярав, Тоног төхөөрөмжийн оператор, Фермер, Манаач гэсэн орон тоон дээр 10 хүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүний нөөцийн өнөөгийн байдалд ерөнхий байдлаар шинжилгээ хийж үзвэл:

Албан хаагчдын 50 хувь нь улсад 13-аас дээш жил ажиллаж байгаа нь туршлагатай, чадвартай боловсон хүчинээр хүний нөөцөө бүрдүүлсэн байна. Үлдсэн нь 40 хувь нь тухайн байгууллагад 3-аас дээш жил ажиллаж байгаа, 1 албан хаагч 1 жил ажиллаж байгаагаас үзэхэд байгууллагын үйл ажиллагааг амжилттай хөтөлж явуулахын тулд тэднийг сургалтанд хамруулж, мэдлэг, чадварыг нь дээшлүүлэх шаардлагатай болохыг харуулна.



Нийт албан хаагчдын боловсролын байдал, мэргэжлийн зэргийг нь авч үзвэл шинжлэх ухааны доктор зэрэгтэй 1, магистр зэрэгтэй 3, бакалавр зэрэгтэй 3, бүрэн дунд боловсролтой 2, тусгай мэргэжлийн зэрэгтэй 1 хүн байна.




Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг Газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/17 тоот тушаалаар баталсан.

Тус хөтөлбөрт “Үйл ажиллагааны стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, өнөөгийн хүний нөөцийг үнэлэх, ирээдүйн хэрэгцээг тодорхойлох, түүнд хүрэхэд учирч болох эрсдэлийг тооцох, гүйцэтгэлд суурилсан бүтээлч байдал, чадварлаг , тогтвортой суурьшилтай боловсон хүчин бий болгохын тулд албан хаагчдын авьяас, чадварыг нээн илрүүлэх замаар үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон.

Мөн “Албан хаагчдийг сонгон шалгаруулах болон сул орон тоог нөхөхдөө Монгол Улсын Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, засгийн газрын 62 дугаар тогтоол зэрэг холбогдох дүрэм журмуудыг баримтлан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хүрээнд ажиллана гэж тусгасны дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

**Байгууллагын хэмжээнд жендерийн тэгш байдлын хувьд /2019.01 сарын байдлаар/**

Нийт албан хаагчид	Үүнээс		Удирдах албан тушаалтан	Үүнээс		Гүйцэтгэх албан тушаалтан	Үүнээс	
	Эр	Эм		Эр	Эм		Эм	Эр
10	6	4	1	1	-	9	4	5



Тус хөтөлбөрийн 3.1-д албан хаагчдыг байнгын сургалтанд хамруулж, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх зарчмыг баримталж ажиллах, 3.3-т албан хаагчдын ажиллах нөхцөл болон нийгмийн баталгааг хангаж ажиллах гэсэн зарчмыг мөрдөн ажиллаж байна.

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”-ОНӨТҮГ- нь боловсон хүчний, санхүүгийн болон материаллаг нөөцийн ашигпалт, үр ашгийг дээшлүүлэх, шинээр нөөц бүрдүүлэх арга хэмжээг дор дурдсан байдлаар хэрэгжүүлж ажиллана.

**Боловсон хүчний мэргэшсэн байдал.** Чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр газрын тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангах, тэднийг чадваржуулах, ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулна:

Нэг. Төрийн албыг мэргэшсэн боловсон хүчинээр бэхжүүлэх бодлогод нийцүүлэн дор дурдсан ажлыг хэрэгжүүлнэ:

1.1 Төрийн захиргааны тухайн албан тушаалд тавигдах нөхцөл, болзлыг хангасан иргэн, албан хаагчийг гагцхүү сонгон шалгаруулалтын журмаар төрийн албанд шинээр авна.

1.2 Төрийн захиргааны тухайн албан тушаалд тавигдах ажлын байрны тодорхойлолтыг нийслэлийн Засаг даргын эрхлэх ажлын хүрээний үйл ажиллагаатай уялдуулан оновчтой тодорхойлно.

**Хоёр.** Төрийн захиргааны албан хаагчдын ажлын үр дүнгийн үнэлгээг сайжруулах, тэдний мэдлэг, мэргэшил, ур чадварыг байнга дээшлүүлэх чиглэлээр дор дурдсан ажлыг хэрэгжүүлнэ:

2.1 Байгууллагын албан хаагчдыг дотоод, гадаадад сургах, давтан сургах үйл ажиллагааг зохицуулах журамд заасны дагуу мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодын сургалтад урт, богино хугацаагаар хамруулна.

2.2 Төрийн албан хаагчдад үндсэн ажлаасаа хөндийрөхгүйгээр өөрийн мэдлэг, мэргэшил, ур чадвараа ахиулах боломжийг олгоно.

**Гурав.** Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, урамшуулах арга хэрэглүүрийг боловсронгуй болгоно. Энэ хурээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.1. Төрийн албан хаагчдыг хэрэгцээтэй компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажлын өрөө тасалгаагаар хангаж, техникийн засвар, үйлчилгээг тогтмолжуулна. Мэдээллийн технологийн гадаад, дотоод сүлжээний найдвартай ажиллагааг хангах арга хэмжээ авна.

3.2. Төрийн захиргааны ба үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж дүгнэсний үндсэн дээр хагас ба бүтэн жилээр тогтоосон журмын дагуу урамшуулал олгоно.

**Дөрөв.** Байгууллагын дотоод ажлын зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1 Байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, хяналт, ажлын уялдаа холбоог сайжруулж, албан хаагчдын ажил үүргийн хуваарийг оновчтой тогтоох, ажлын давхардлыг арилгах, ажлын ачааллыг жигдүүлэх ажлыг судлан шийрдвэрлэнэ.

4.2 Албан хаагчдын ажил хэргийн уялдаа холбоог сайжруулж, харилцан мэдээлэл солилцох оновчтой арга, хэлбэрийг тогтоож мөрдүүлнэ.

Ерөнхий менжер (Байгууллагын дарга) Төсвийн ерөнхийлөн захирагч (Нийслэлийн Засаг дарга)-ийн эрхлэх асуудлын хүрээнд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 18.3.3-т зааснаар үр дүнгийн гэрээ байгуулж, түүний өмнө хариуцлага хүлээнэ.

## **ЗУРГАА. ТӨСӨВЛӨСӨН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Төсөвлөсөн санхүүгийн тайланг Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 253 дугаар тушаалаар баталсан санхүүгийн тайлантай ижил загвараар гаргах бөгөөд ингэхдээ төсвийн байгууллагад мөрдөх Нягтан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлангийн загвар, тайланг бэлтгэж гаргах аргачлал, бүтээгдэхүүний өртөг тооцох аргачлал зэргийг удирдамж болгоно.

### **6.1 Төсөвлөсөн санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдээлэл**

Дээд байгууллагын нэр:

Байгууллагын нэр: Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ

Регистрийн дугаар: 6046231

Байршил: Улаанбаатар аймаг/хот Сүхбаатар сум/дүүрэг

**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН 2018 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

Хянаж хүлээж авсан байгууллагын нэр	Он, сар, өдөр	Гарын үсэг

**Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ**  
**(байгууллагын нэр )**

**2018 оны санхүүгийн тайлангийн  
бодит байдлын тухай мэдэгдэл**

2018 он 12 сар 31 өдөр.

Ерөнхий менежер Г.Галдөл ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхдөл бид манай байгууллагын 2018 оны 12 сарын 31 -ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг "Нягтлан бodoх бүртгэлийн тухай", "Төсвийн тухай" хуулийн холбогдох заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бodoх бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан.
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн.
3. Байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан;
4. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгагдана.
5. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байdag бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Ерөнхий менежер Г.Галдөл /  
Ерөнхий нягтлан бодогч Ц.Мөнхдөл /



## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 он 12 сар 31 өдөр.

/төгрөгөөр/

Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тодруулга	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>79,594,221.50</b>	<b>127,386,144.28</b>
	<b>МОНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		0.00	0.00
3121	Төгрөг		0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах		0.00	0.00
33	<b>АВЛАГА</b>		<b>7,102,000.00</b>	<b>2,103,402.32</b>
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага			15,402.32
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		7,102,000.00	2,088,000.00
335	Бусад авлага			0.00
3351	Байгууллагаас авах авлага			0.00
34	<b>УРЬДЧИЛГАА</b>			<b>11,673.46</b>
34600	Урьдчилж гарсан зардал			11,673.46
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		<b>72,492,221.50</b>	<b>125,271,068.50</b>
351	Түүхий эд материал		35,229,216.63	27,091,359.43
35110	Тусгай зориулалттай материал		35,229,216.63	27,091,359.43
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		16,393,502.87	35,234,221.08
354	Хангамжийн материал		20,869,502.00	29,585,487.99
35410	Бичиг хэргийн материал		407,870.00	595,570.00
35420	Аж ахуйн материал		2,499,130.00	3,830,238.00
35430	Сэлбэг хэрэгсэл			824,600.00
35440	Түлш шатах тослох материал			102,440.00
35470	Бусад хангамжийн материал		17,962,502.00	24,232,639.99
35600	Мал, амьтад			33,360,000.00
	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,001,606,858.14</b>	<b>1,141,259,849.30</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		<b>1,001,606,858.14</b>	<b>1,141,259,849.30</b>
392	Биет хөрөнгө		1,000,512,191.48	1,136,626,516.00
39203	Авто тээврийн хэрэгсэл		490,750,000.00	563,363,658.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(48,860,000.04)	(99,360,227.68)
39205	Машин, тоног төхөөрөмж		453,463,600.00	620,026,461.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(30,676,275.58)	(74,455,267.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		12,629,797.00	21,814,797.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(3,927,247.26)	(7,294,426.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө		141,886,226.40	141,886,226.40
39215	Хуримтлагдсан элэгдэл		(14,753,909.04)	(29,354,704.68)
393	<b>Биет бус хөрөнгө</b>		<b>1,094,666.66</b>	<b>4,633,333.30</b>
39301	Програм хангамж		520,000.00	520,000.00
39302	Хасагдуулга		(173,333.40)	(346,666.80)
39303	Бусад биет бус хөрөнгө		880,000.00	4,680,000.00
39304	Хасагдуулга		(131,999.94)	(219,999.90)
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,081,201,079.64</b>	<b>1,268,645,993.58</b>
	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>			<b>27,075.78</b>
	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			<b>27,075.78</b>
413	Өглөг			<b>27,075.78</b>
4131	Ажиллагчидтай холбогдсон өглөг			<b>27,075.78</b>
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг			0.00
	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>		<b>1,081,201,079.64</b>	<b>1,268,618,917.80</b>
51	Засгийн газрын хувь оролцоо		1,081,201,079.64	1,268,618,917.80
	Хуримтлагдсан үр дүн		1,081,201,079.64	1,268,618,917.80
51210	Өмнөх үеийн үр дүн		1,081,201,079.64	1,081,201,079.64

## САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 он 12 сар 31 өдөр.

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		226,978,680.00	564,157,963.00
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,781,380.00	310,403,363.00
	Нийтлэг татварын бус орлого		4,781,380.00	310,403,363.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого		4,781,380.00	310,403,363.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			19,538,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		4,781,380.00	290,864,863.00
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		222,197,300.00	253,754,600.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого		9,102,000.00	
ДТ(131105)	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		9,102,000.00	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		213,095,300.00	253,754,600.00
ДТ(132001)	Ургал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуулага/		213,095,300.00	253,754,600.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)		265,924,770.28	376,740,124.84
	ҮРСГАЛ ЗАРДАЛ		257,320,285.88	338,923,909.51
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		257,320,285.88	338,923,909.51
2101	Цалин, холс болон нэмэгдэл урамшил		93,586,841.91	98,628,935.25
210101	Цалин		75,280,347.94	80,426,192.28
210102+*	Нэмэгдэл цалин		11,697,494.87	12,005,843.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6,608,999.10	6,196,899.37
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		10,244,575.51	11,824,530.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл		6,545,457.80	7,890,314.04
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		909,723.00	986,289.26
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		773,394.53	789,031.40
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		183,272.74	196,255.04
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж		1,832,727.44	1,962,640.26
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		33,921,200.00	43,609,337.50
210301	Гэрэл цахилгааны зардал			6,483,137.50
210302	Түлш, халаалтын зардал		1,250,000.00	1,665,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал			2,790,000.00
210304	Байрны түрээс		32,671,200.00	32,671,200.00
	Хангамж, бараа материалын зардал		18,991,672.18	24,994,014.52
210401+*	Бичиг хэргийн материал		1,148,090.00	1,279,650.00
210402+*	Тээвэр, шатахууны зардал		14,423,731.00	18,012,679.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр		2,245,651.18	2,409,062.92
210405+*	Хог хаяжал устгах, цэвэрлэх		316,000.00	520,000.00
210406+*	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс		858,200.00	1,012,540.00
210408	Бараа материал актасны зардал			1,760,082.60
	Нормативт зардал		1,494,500.00	2,078,800.00
210501	Эм			1,471,800.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,494,500.00	607,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж		4,031,065.00	20,767,764.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,759,065.00	16,485,164.40
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр		168,000.00	4,009,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		38,000.00	127,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр			80,000.00
220103	Бараа үйлчилгээний бусад зардал		95,050,431.28	137,020,527.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			24,012,000.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал		500,000.00	500,000.00
КТ(210903)	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		94,550,431.28	112,508,527.84
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,604,484.40	37,816,215.33
	Бусад урсгал шилжүүлэг		5,168,457.00	1,994,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		5,168,457.00	1,994,500.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,436,027.40	35,821,715.33
КТ(213303)	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,436,027.40	35,821,715.33
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)		(38,946,090.28)	187,417,838.16
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДЛЫН ДҮН (V)		39,274,380.00	
КТ(225005)	Үнэ төлбөргүй гарсан зардал		39,274,380.00	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ҮР ДҮН (VI=IV-V)		(39,274,380.00)	
	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	УЛААНБААТАР ХОТ	(78,220,470.28)	187,417,838.16

Ерөнхий менежер:  
Нягтлан бодогч:  
Баталгаажуулсан:

БЭЛЧЭЭРИЙН  
МЕНЕДЖМЕНТ  
ТӨСЛИЙН ИЭГЖ  
УИРЛЭЛ  
6046231-1116117863

/ Г.Галдөл /

/ Ц.МОНХДОЛ /

/ /

## МОНГОН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 он 12 сар 31 өдөр.

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МОНГОН ОРЛОГЫН ДҮН (I)		215,095,300.00	276,007,100.00
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО			17,238,500.00
	Нийтлэг татварын бус орлого			17,238,500.00
	Төсөвт байгууллагын оорийн орлого			17,238,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			17,238,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		215,095,300.00	258,768,600.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,000,000.00	5,014,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,000,000.00	5,014,000.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		213,095,300.00	253,754,600.00
132001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		213,095,300.00	253,754,600.00
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)		198,255,270.00	263,022,100.00
	ҮРСГАЛ ЗАРДАЛ		198,255,270.00	263,022,100.00
	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		189,650,785.60	225,205,884.67
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		94,567,180.71	98,628,926.35
210101	Үндсэн цалин		67,618,800.00	70,273,326.35
210102	Нэмэгдэл		20,339,380.71	20,853,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6,609,000.00	7,502,000.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл		9,264,236.71	11,824,538.90
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл		5,913,379.49	7,890,314.06
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл		755,452.88	986,289.26
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		557,475.64	624,229.08
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл		374,043.37	361,066.35
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж		1,663,885.33	1,962,640.15
	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал		33,921,200.00	43,609,337.50
210301	Гэрэл цахилгааны зардал			6,483,137.50
210302	Түлш, халаалтын зардал		1,250,000.00	1,665,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал			2,790,000.00
210304	Байрны түрэс		32,671,200.00	32,671,200.00
220103	Хангамж, бараа материалын зардал		32,102,318.18	31,476,829.92
210401	Бичиг хэрэг		1,467,700.00	1,467,350.00
210402	Тээвэр, шатахуун		25,816,667.00	24,883,019.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,265,651.18	2,409,062.92
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		316,000.00	520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,236,300.00	2,197,398.00
22010310	Нормативт зардал		1,494,500.00	2,078,800.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл			1,471,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,494,500.00	607,000.00
	Эд хогшил, ургал засварын зардал			185,000.00
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл			185,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		17,801,350.00	36,902,452.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж		15,573,450.00	32,619,852.00
210803	Даатгалын үйлчилгээ		2,000,000.00	4,021,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		227,900.00	115,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			66,000.00
210807	Газрын төлбөр			80,000.00
	Бараа үйлчилгээний бусад зардал		500,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх		500,000.00	500,000.00
	ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,604,484.40	37,816,215.33
	Бусад ургасал шилжүүлэг		5,168,457.00	1,994,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		5,168,457.00	1,994,500.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,436,027.40	35,821,715.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3,436,027.40	35,821,715.33
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		16,840,030.00	12,985,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		16,840,030.00	12,985,000.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		16,840,030.00	12,985,000.00
	Дотоод эх үүсвэрээр		16,840,030.00	12,985,000.00
2	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		16,840,030.00	12,985,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(16,840,030.00)	(12,985,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
ЭХ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00
ЭЦ.ДТ(31)	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			0.00

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 он 12 сар 31 өдөр.

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний неөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 1-р сарын 1-ээрх Үлдэгдэл	0.00	0.00	1,159,421,549.92	1,159,421,549.92
2	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн Үлдэгдэл	0.00	0.00	1,159,421,549.92	1,159,421,549.92
4	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
5	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайландаа хүлээн зөвшөөрөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үсийн үр дүн /Цэвэр ашиг аллагдал/	0.00	0.00	-78,220,470.28	-78,220,470.28
8	2017 оны 12-р сарын 31-ээрх Үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
9	2017 оны 12-р сарын 31-ээрх Үлдэгдэл	0.00	0.00	1,081,201,079.64	1,081,201,079.64
10	Нягтлан бодох бүртгэлийн боллогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
11	Дахин илэрхийлсэн Үлдэгдэл	0.00	0.00	1,081,201,079.64	1,081,201,079.64
12	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
13	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	0.00	0.00	0.00	0.00
14	Орлогын тайландаа хүлээн зөвшөөрөгүй олз гарз	0.00	0.00	0.00	0.00
15	Гадаад валютын хорвулэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
16	Тайлант үсийн үр дүн /Цэвэр ашиг аллагдал/	0.00	0.00	187,417,838.16	187,417,838.16
17	2018 оны 12-р сарын 31-ээрх Үлдэгдэл	0.00	0.00	1,268,618,917.80	1,268,618,917.80



## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2018 он 12 сар 31 өдөр.

/төгрөгөөр/

	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДУН	253,754,600.00	240,185,384.67	13,569,215.33	94.7%
УРСГАЛ ЗАРДЛЫН ДУН	253,754,600.00	240,185,384.67	13,569,215.33	94.7%
Бараа, үйлчилгээний зардал	251,754,600.00	238,190,884.67	13,563,715.33	94.6%
Цалин холс болон нэмэгдэл урамшил	98,653,000.00	98,628,326.35	24,073.65	100.0%
Үндсэн цалин	70,297,400.00	70,273,326.35	24,073.65	100.0%
Нэмэгдэл	20,853,600.00	20,853,600.00		100.0%
Унаа, болон бусад ихэхэн олговор	7,502,000.00	7,502,000.00		100.0%
Ажил олгожсоос нийгмийн даатгалд толох шимтгэл	11,838,400.00	11,824,538.90	13,861.10	99.9%
Тэтгэврийн даатгал	7,999,500.00	7,890,314.06	109,185.94	98.6%
Тэтгэмжийн даатгал	959,700.00	986,289.26	(26,589.26)	102.8%
YOMSH нийт даатгал	767,800.00	624,229.08	143,570.92	81.3%
Ажилгүйдлийн даатгал	191,900.00	361,066.35	(169,166.35)	188.2%
Эрүүл мэндийн даатгал	1,919,500.00	1,962,640.15	(43,140.15)	102.2%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,986,200.00	43,609,337.50	3,376,862.50	92.8%
Гэрэл цахилгаан	9,500,000.00	6,483,137.50	3,016,862.50	68.2%
Түлш, халаалт	1,665,000.00	1,665,000.00		100.0%
Цэвэр, бохир ус	3,150,000.00	2,790,000.00	360,000.00	88.6%
Байрны түрээс	32,671,200.00	32,671,200.00		100.0%
Хангамж, бараа материалын зардал	33,745,600.00	31,476,829.92	2,268,770.08	93.3%
Бичиг хэрэг	1,467,600.00	1,467,350.00	250.00	100.0%
Тээвэр (шатахуун)	26,408,000.00	24,883,019.00	1,524,981.00	94.2%
Шуудан холбоо, интернетийн төлбөр	3,150,000.00	2,409,062.92	740,937.08	76.5%
Хог хаягдал зайлцуулах, хортон мэргэгчийн устгал, ариутгал	520,000.00	520,000.00		100.0%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,200,000.00	2,197,398.00	2,602.00	99.9%
Нормативт зардал	4,960,000.00	2,078,800.00	2,881,200.00	41.9%
Эм бодлымз, эмизэгтийн хэрэгсэл	1,500,000.00	1,471,800.00	28,200.00	98.1%
Нормын хувцас зөвлөн эдлэл	3,460,000.00	607,000.00	2,853,000.00	17.5%
Эд хогшил худалдан авах	9,370,000.00	9,370,000.00		100.0%
Багаж, техник, хэрэгсэл	7,100,000.00	7,100,000.00		100.0%
Тавилга				
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,270,000.00	2,270,000.00		100.0%
Ургал засвар				
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	45,701,400.00	40,702,452.00	4,998,948.00	89.1%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,462,000.00	36,419,852.00	42,148.00	99.9%
Даатгалын үйлчилгээ	8,977,800.00	4,021,600.00	4,956,200.00	44.8%
Тээврийн хэрэгслийн татвар	115,000.00	115,000.00		100.0%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,600.00	66,000.00	600.00	99.1%
Газрын төлбөр	80,000.00	80,000.00		100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00		100.0%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00		100.0%
УРСГАЛ НИЙЛЖҮҮЛГЭТ	2,000,000.00	1,994,500.00	5,500.00	99.7%
Бусад ургал шилжүүлэгт	2,000,000.00	1,994,500.00	5,500.00	99.7%
Ажил олгожсоос олгох бусад тэтгэмж, урамшуулал				
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,000,000.00	1,994,500.00	5,500.00	99.7%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	253,754,600.00	240,185,384.67	13,569,215.33	94.7%
ОРОН НҮҮГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	253,754,600.00	222,946,884.67	30,807,715.33	87.9%
Орон нүүгийн төсвөөс	253,754,600.00	222,946,884.67	30,807,715.33	87.9%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		17,238,500.00	(17,238,500.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	
Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих		17,238,500.00	(17,238,500.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	10.00	9.00	1.00	90.0%
АЖИЛЛАГСДЫН ТОО				